



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/331

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 /а/, 29.1.6 /г/, 29,2, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Бизнес хөгжлийн төвийг түшиглэн Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийн хүрээнд баг бүрээс ажилгүй иргэдийг сургах оёдлын сургалтыг зохион байгуулахад шаардлагатай 6000000 /зургаан сая/ төгрөгийг хавсралтаар баталж Засаг даргын бусад зардлын аймгийн жижиг дунд бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж байгууллагуудыг олон нийтэд таниулан сурталчилах, чадавхижуулах, урамшуулах зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

Хоёр.Захирамжийн хэрэгжилтийг ханган, дээрх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /н.Баяржаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 6-  
дугаар сарын 15-ны өдрийн 133/  
дугаар захирамжийн хавсралт

**ЖДУ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ТӨСӨВ**

№	Зориулалт	Тоо хэмжээ	Үнэ	Нийт	Тайлбар
<b>Загварын монгол дээл - 3 өдөр</b>					
1	Багшийн хөлс	24	60,000	1,440,000	60 минутыг 1 цагт тооцож хөлс олгоно.
2	Телевиз зардал	1	40,000	40,000	Бичлэг хийж түүнийгээ эмхэтгэн ТВ цацахаар бэлдэж өгнө.
3	Сургалтын өрөөний түрээс	18	60,000	1,080,000	
4	Кофе завсарлага	90	3,500	315,000	Бургер кофе бэлтгэнэ.
5	Сургалтын материалын зардал	22	50,000	1,100,000	Дээлний болон туслах материал авна
6	Гарын авлага	22	5,500	121,000	Оролцогчидод гарын авлага олшруулна.
<b>Дүн</b>				<b>4,096,000</b>	
<b>Даалин оёх - 3 өдөр</b>					
1	Багшийн хөлс	15	60,000	900,000	60 минутыг 1 цагт тооцож хөлс олгоно.
2	Сургалтын өрөөний түрээс	3	50,000	150,000	
3	Кофе завсарлага	90	3,500	315,000	Бургер кофе бэлтгэнэ.
4	Сургалтын материалын зардал	22	24,500	539,000	Дээлний болон туслах материал авна
<b>Дүн</b>				<b>1,904,000</b>	
<b>Нийт дүн</b>				<b>6,000,000</b>	